

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны Яам
МУ	Монгол Улсын
ТШЗ	Төсвийн Шууд Захирагч
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн Захирагч
НБББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичиг
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуучлалын яам

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14
3.Аудитын тайлан	15
3.1. Ерөнхий зүйл	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал.....	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	17
3.7. Шилэн дансны мэдээлэл	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.9. Аудитын илрүүлэлт	19
Залруулсан алдаа.....	19
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	19
Аудитын зөвлөмж	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	19
4. Менежментийн захидал.....	19
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХИМИ, ХИМИЙН ТЕХНОЛОГИЙН
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ
Л.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

2021.02.25 № 07/599

танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 19 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>614,904,886.51</u>	<u>472,264,325.26</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	1,061,108.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	1,061,108.00
31110	Төгрөг	-	1,061,108.00
33	АВЛАГА	380,306,372.11	179,459,528.80
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	76,886.22	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	380,229,485.89	175,059,528.80
335	Бусад авлага	-	4,400,000.00
3351	Байгууллагаас авах авлага	-	4,400,000.00
34	УРЬДЧИЛГАА	146,000,000.00	225,891,500.00
34600	Урьдчилж гарсан зардал	146,000,000.00	225,891,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	88,598,514.40	65,852,188.46
351	Түүхий эд материал	11,904,461.96	12,159,893.96
35110	Тусгай зориулалттай материал	11,904,461.96	12,159,893.96
35300	Бэлэн бүтээгдэхүүн	704,770.00	596,125.00
354	Хангамжийн материал	75,989,282.44	53,096,169.50
35410	Бичиг хэргийн материал	4,536,399.00	3,593,899.00
35420	Аж ахуйн материал	16,126,197.00	10,836,198.00
35430	Сэлбэг хэрэгсэл	42,583,870.00	27,226,550.00
35440	Түлш, шатах тослох материал	217,000.00	247,000.00
35470	Бусад хангамжийн материал	12,525,816.44	11,192,522.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,496,402,209.22</u>	<u>7,509,690,166.26</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,496,402,209.22	7,509,690,166.26
392	Биет хөрөнгө	7,304,471,391.96	7,328,598,566.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,982,909,418.00	5,991,380,858.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	(163,314,725.76)	(326,629,451.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	15,913,000.00	24,913,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(15,663,000.06)	(16,079,666.69)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,024,253,693.81	3,377,920,993.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,816,005,538.57)	(1,973,114,602.67)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	353,109,063.16	357,432,613.16
39208	Хуримтлагдсан элэгдэл	(86,449,766.65)	(116,581,925.63)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,900,000.00	2,900,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,842,708.13)	(2,205,208.09)
39217	Ном	8,661,956.16	8,661,956.16
393	Биет бус хөрөнгө	191,930,817.26	181,091,599.62
39301	Програм хангамж	550,000.00	5,135,610.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(412,500.06)	(2,137,805.02)
39303	Бусад биет бус хөрөнгө	205,492,840.00	205,492,840.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(13,699,522.68)	(27,399,045.36)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>8,111,307,095.73</u>	<u>7,981,954,491.52</u>

4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	22,756,855.91
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	22,756,855.91
413	Өглөг	-	333,800.00
4136	Бусад өглөг	-	333,800.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	333,800.00
414	Урьдчилж орсон орлого	-	22,423,055.91
41440	Бусад урьдчилж орсон орлого	-	22,423,055.91
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,111,307,095.73	7,959,197,635.61
51	Засгийн газрын хувь оролцоо	8,111,307,095.73	7,959,197,635.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,282,597,658.51	3,282,597,658.51
51101	Өмч: - төрийн	3,282,597,658.51	3,282,597,658.51
512	Хуримтлагдсан үр дүн	1,827,762,148.77	1,675,652,688.65
51210	Өмнөх үеийн үр дүн	1,827,762,148.77	1,827,762,148.77
51220	Тайлант үеийн үр дүн	-	(152,109,460.12)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,000,947,288.45	3,000,947,288.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,111,307,095.73	7,981,954,491.52

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,738,829,341.00	3,071,772,875.11
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,668,053,900.00	33,504,118.11
120	Нийтлэг татварын бус орлого	2,668,053,900.00	33,504,118.11
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,663,349,900.00	33,504,118.11
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,841,900.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,061,108.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,651,508,000.00	18,551,440.11
120005	Түрээсийн орлого	4,704,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,070,775,441.00	3,038,268,757.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,902,154,500.00	2,677,271,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,902,154,500.00	2,677,271,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,168,620,941.00	360,997,257.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	296,555,041.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	452,727,000.00	117,366,344.09
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	419,338,900.00	243,630,912.91
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,820,413,450.39	3,223,587,737.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,820,413,450.39	3,223,587,737.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,802,175,682.49	3,184,766,680.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,467,540,345.08	1,885,048,252.56
210101	Үндсэн цалин	1,197,803,594.08	1,352,267,917.25
210102	Нэмэгдэл	194,806,451.00	343,838,476.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	74,930,300.00	148,686,599.00
210104	Урамшуулал	-	40,255,260.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	185,139,971.11	240,484,615.51
210201	Тэтгэврийн даатгал	130,353,354.11	167,326,715.52
210202	Тэтгэмжийн даатгал	14,283,364.00	18,366,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,321,731.00	14,692,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,641,954.00	3,367,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,539,568.00	36,732,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,646,438.76	89,484,914.82
210301	Гэрэл, цахилгаан	25,749,026.00	27,470,980.00
210302	Түлш, халаалт	49,332,268.41	48,421,595.00
210303	Цэвэр, бохир ус	13,565,144.35	13,592,339.82
2104	Хангамж, бараа материалын зардал	112,855,304.13	52,320,682.11
210401	Бичиг хэрэг	12,995,642.00	10,108,140.00
210402	Тээвэр, шатахуун	14,575,000.00	2,915,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,702,037.22	1,596,057.59
210404	Ном, хэвлэл	2,434,797.00	226,154.58

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,040,000.00	1,830,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	79,107,827.91	35,644,829.94
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	104,684,326.00	62,294,119.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	231,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,382,000.00	11,179,500.00
210604	Урсгал засвар	89,071,326.00	51,114,619.00
2107	Томилолт, зочны зардал	18,295,400.00	18,044,500.00
210701	Гадаад албан томилолт	5,300,000.00	-
210702	Дотоод албан томилолт	12,995,400.00	18,044,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	332,270,710.51	366,403,707.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	328,444,600.51	363,006,827.12
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	71,280.00	71,280.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,100.00	69,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	1,662,730.00	1,233,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	492,743,186.90	470,685,889.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	118,563,465.40	93,621,394.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,348,529.18	7,622,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	353,831,192.32	369,441,795.69
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,237,767.90	38,821,057.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,951,900.00	6,343,620.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,951,900.00	6,343,620.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,285,867.90	32,477,437.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,285,867.90	31,902,437.04
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	575,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,918,415,890.61	(151,814,862.74)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,323,680.84	294,597.38
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,323,680.84	294,597.38
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(4,323,680.84)	(294,597.38)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,914,092,209.77	(152,109,460.12)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,205,853,417.20	3,441,982,406.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,545,900.00	1,061,108.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,545,900.00	1,061,108.00

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,841,900.00	1,061,108.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,841,900.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,061,108.00
120005	Түрээсийн орлого	4,704,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,189,307,517.20	3,440,921,298.80
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,902,154,500.00	2,677,271,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,902,154,500.00	2,677,271,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,287,153,017.20	763,649,798.80
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	415,087,117.20	203,539,485.89
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	452,727,000.00	316,479,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	419,338,900.00	243,630,912.91
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,970,406,941.58	3,090,259,958.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,970,406,941.58	3,090,259,958.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,571,939,687.79	2,876,379,372.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,469,269,477.56	1,885,048,252.56
210101	Үндсэн цалин	1,218,085,772.56	1,352,267,917.25
210102	Нэмэгдэл	205,881,305.00	343,838,476.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,302,400.00	148,686,599.00
210104	Урамшуулал	-	40,255,260.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	182,337,774.56	240,484,615.51
210201	Тэтгэврийн даатгал	127,539,308.56	167,326,715.51
210202	Тэтгэмжийн даатгал	14,106,466.00	18,366,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,851,200.00	14,692,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,712,800.00	3,367,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	27,128,000.00	36,732,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,646,438.76	89,484,914.82
210301	Гэрэл, цахилгаан	25,749,026.00	27,470,980.00
210302	Түлш, халаалт	49,332,268.41	48,421,595.00
210303	Цэвэр, бохир ус	13,565,144.35	13,592,339.82
2104	Хангамж, бараа материалын зардал	50,195,916.22	32,586,103.17
210401	Бичиг хэрэг	1,918,147.00	1,437,640.00
210402	Тээвэр, шатахуун	2,750,000.00	1,955,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,713,027.22	1,710,457.59
210404	Ном, хэвлэл	8,751,050.00	7,337,654.58
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,040,000.00	1,830,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	33,023,692.00	18,315,351.00
2105	Нормативт зардал	-	4,986,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	4,986,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	219,318,176.00	186,400,772.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	161,401,500.00	94,953,870.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,382,000.00	19,790,137.00
210604	Урсгал засвар	42,534,676.00	71,656,765.00

2107	Томилолт, зочны зардал	25,545,400.00	18,044,500.00
210701	Гадаад албан томилолт	5,300,000.00	-
210702	Дотоод албан томилолт	20,245,400.00	18,044,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	508,765,245.51	395,072,123.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	504,939,135.51	392,009,043.90
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	71,280.00	71,280.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	70,100.00	69,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	1,662,730.00	900,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,861,259.18	24,272,091.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,832,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,861,259.18	15,439,591.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	398,467,253.79	213,880,585.84
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,951,900.00	6,343,620.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14,951,900.00	6,343,620.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	383,515,353.79	207,536,965.84
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	383,515,353.79	31,902,437.04
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	175,634,528.80
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	235,446,475.62	351,722,448.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	235,446,475.62	350,661,340.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	235,446,475.62	350,661,340.00
2200	Дотоод эх үүсвэрээр	235,446,475.62	350,661,340.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	235,446,475.62	350,661,340.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(235,446,475.62)	(350,661,340.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	1,061,108.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,061,108.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,282,597,658.51	3,066,731,448.02	(1,151,973,887.57)	5,197,355,218.96
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	65,643,826.57	65,643,826.57
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,282,597,658.51	3,066,731,448.02	(1,086,330,061.00)	5,262,999,045.53
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	(65,784,159.57)	-	(65,784,159.57)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	2,914,092,209.77	2,914,092,209.77
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,282,597,658.51	3,000,947,288.45	1,827,762,148.77	8,111,307,095.73
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,282,597,658.51	3,000,947,288.45	1,827,762,148.77	8,111,307,095.73
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(152,109,460.12)	(152,109,460.12)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,282,597,658.51	3,000,947,288.45	1,675,652,688.65	7,959,197,635.61

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,677,271,500.00	2,645,369,062.96	31,902,437.04	98.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,677,271,500.00	2,645,369,062.96	31,902,437.04	98.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,670,921,500.00	2,639,025,442.96	31,896,057.04	98.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,836,597,900.00	1,836,548,252.56	49,647.44	100.00
210101	Үндсэн цалин	1,269,539,800.00	1,303,767,917.25	(34,228,117.25)	102.70
210102	Нэмэгдэл	366,206,900.00	343,838,476.31	22,368,423.69	93.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт	200,851,200.00	148,686,599.00	52,164,601.00	74.03
210104	Урамшуулал	-	40,255,260.00	(40,255,260.00)	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	247,940,800.00	234,422,117.51	13,518,682.49	94.55
210201	Тэтгэврийн даатгал	174,476,800.00	161,264,217.51	13,212,582.49	92.43
210202	Тэтгэмжийн даатгал	18,366,000.00	18,366,000.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,692,800.00	14,692,800.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,673,200.00	3,367,100.00	306,100.00	91.67
210205	Эрүүл мэндийн даатгал	36,732,000.00	36,732,000.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,391,900.00	89,484,914.82	2,906,985.18	96.85
210301	Гэрэл, цахилгаан	27,788,700.00	27,470,980.00	317,720.00	98.86
210302	Түлш, халаалт	48,494,200.00	48,421,595.00	72,605.00	99.85
210303	Цэвэр, бохир ус	16,109,000.00	13,592,339.82	2,516,660.18	84.38
2104	Хангамж, бараа материалын зардал	18,440,700.00	17,342,112.17	1,098,587.83	94.04
210401	Бичиг хэрэг	2,134,800.00	1,437,640.00	697,160.00	67.34
210402	Тээвэр, шатахуун	1,956,900.00	1,955,000.00	1,900.00	99.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,001,400.00	1,710,457.59	290,942.41	85.46
210404	Ном, хэвлэл	407,000.00	391,154.58	15,845.42	96.11
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,912,400.00	1,830,000.00	82,400.00	95.69
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,028,200.00	10,017,860.00	10,340.00	99.90
2105	Нормативт зардал	5,000,000.00	4,986,000.00	14,000.00	99.72
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,000,000.00	4,986,000.00	14,000.00	99.72
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	362,063,200.00	361,974,292.00	88,908.00	99.98
210601	Багаж, техник, хэрэгсэл	276,800,000.00	276,792,390.00	7,610.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	19,863,200.00	19,790,137.00	73,063.00	99.63
210604	Урсгал засвар	65,400,000.00	65,391,765.00	8,235.00	99.99

2107	Томилолт, зочны зардал	15,000,000.00	14,902,500.00	97,500.00	99.35
210702	Дотоод албан томилолт	15,000,000.00	14,902,500.00	97,500.00	99.35
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	93,487,000.00	79,365,253.90	14,121,746.10	84.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	90,285,000.00	76,302,173.90	13,982,826.10	84.51
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	71,280.00	128,720.00	35.64
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	69,800.00	10,200.00	87.25
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	-	100.00
210807	Газрын төлбөр	900,000.00	900,000.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,350,000.00	6,343,620.00	6,380.00	99.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,350,000.00	6,343,620.00	6,380.00	99.90
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,350,000.00	6,343,620.00	6,380.00	99.90
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,677,271,500.00	2,646,430,170.96	30,841,329.04	98.85
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,677,271,500.00	2,645,369,062.96	31,902,437.04	98.81
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,677,271,500.00	2,645,369,062.96	31,902,437.04	98.81
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	1,061,108.00	(1,061,108.00)	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,677,271,500.00	2,646,430,170.96	30,841,329.04	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2,677,271,500.00	2,645,369,062.96	31,902,437.04	98.85

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	763,649,798.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	588,015,270.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	588,015,270.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	48,500,000.00
210101	Үндсэн цалин	-	48,500,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	6,062,498.00
210201	Тэтгэврийн даатгал	-	6,062,498.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	15,493,981.00
210404	Ном, хэвлэл	-	6,946,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	8,547,481.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	125,620,370.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	119,355,370.00
210604	Урсгал засвар	-	6,265,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	3,142,000.00
210702	Дотоод албан томилолт	-	3,142,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	364,924,330.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	364,924,330.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	24,272,091.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	8,832,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	15,439,591.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	763,649,798.80
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	203,539,485.89
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	316,479,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	243,630,912.91

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг захирал Л.Жаргалсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн элэгдлийг анхаарах, биет бус хөрөнгө буюу патентын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 18-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Конфиденсе аудит ХХК-ийн ахлах аудитор П.Ариунаа удирдаж, аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ны өдрийн 1/21 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хими, химийн технологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн химийн аж үйлдвэрийг хөгжүүлэх шинжлэх ухааны үндэслэлийг бий болгох, химийн шинжлэх ухааныг шинэ мэдлэг, мэдээллээр баяжуулахад оршино.
- Хүрээлэнгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь туршилтаар баталж болохуйц шинэ мэдлэгийг бий болгож дэлхийн шинжлэх ухаанд хувь нэмэр оруулах, эх орны амьтан ургамал, эрдсийн гаралтай түүхий эдийн хими, физик-хими, биохими, технологийн шинж чанарыг судлан тодорхойлох, тэдгээрийг хувирган өөрчлөх байгаль орчинд ээлтэй хими, биохимийн дэвшилтэт технологи бий болгох, улмаар өгөгдсөн шинж чанартай шинэ бодис, бэлдмэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэх шинжлэх ухааны үндэслэл боловсруулахад оршдог.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хими, химийн технологийн хүрээлэнгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь БШУС-ын 2017 оны бодлогын баримт бичиг, журам батлах тухай А/40 дүгээр тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Өмнөх оны ТЕЗ-ийн аудитаар тус бодлогын баримт бичгийг сайжруулах талаар өгсөн зөвлөмжийн дагуу БШУС-ын 2020 оны А/20 дугаар тушаалаар шалгарсан зөвлөх

үйлчилгээний компани 2021 оны 2 сард хүлээлгэн өгч шинэчилсэн НБББББ-ийг мөрдөхөөр болсон байна.

Боловсрол, Шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд харьяа Хими,химийн технологийн хүрээлэнгийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Хими,химийн технологийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт хөрөнгийн 7,981,954.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 159,639.1 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хими, химийн технологийн хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 129,352.6 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	1,061.1	1,061.1
Авлага	380,306.4	179,456.5	(200,846.8)
Урьдчилж гарсан зардал	146,000.0	225,891.5	79,891.5
Бараа материал	88,598.5	65,852.2	(22,746.3)
Үндсэн хөрөнгө	7,496,402.2	7,509,690.2	13,288.0
Нийт хөрөнгө	8,111,307.1	7,981,954.5	(129,352.6)
Өр төлбөр	-	22,756.9	22,756.9
Засгийн газрын оролцоо	8,111,307.1	7,959,197.6	(152,109.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,111,307.1	7,981,954.5	(129,352.6)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,061.1 мянган төгрөг болж 1,061.1 мянган төгрөгөөр өссөн нь түрээсийн барьцаанаас шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 179,456.5 мянган төгрөг болж 200,846.8 мянган төгрөгөөр буурсан нь Байгаль орчны яамтай хамтарсан төслийн тоног төхөөрөмжийн урьдчилгаа төлбөрт 73,000.0 мянган төгрөг төлсөн. Мөн гадаадтай хамтарсан төслүүд 127,846.8 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн учир татаас санхүүжилтийн авлага буурсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 65,852.2 мянган төгрөг болж 22,746.3 мянган төгрөгөөр өссөн буурсан нь 2020 онд ковид гарсантай холбоотой төсвийн зардлыг 20 хувиар буурсан байна. Мөн 2020 онд хэрэгжих төслүүдийн мөнгө орж ирээгүйтэй холбоотой хангамжийн материалын зардлууд буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,509,690.2 мянган төгрөг болж 13,288.0 мянган төгрөгөөр өссөн нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 271 дүгээр тогтоолоор нэн шаардлагатай тоног төхөөрөмж 353,667.3 мянган төгрөгөөр худалдан авсантай холбоотой байна.

Үнэ төлбөргүй 1,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлсэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны А-1/1879 тоот тогтоолоор 1,976.4 мянган төгрөгийн хөрөнгийн акталж данс бүртгэлээс хассан, тайлант хугацаанд 369,441.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал байгуулсан.

Өр төлбөр дансны үлдэгдэл 22,756.9 мянган төгрөг болж 22,756.9 мянган төгрөгөөр өссөн нь Монгол Улсын Сангийн яамны 7/406 тоот дугаартай бичгийн дагуу урьдчилж олсон орлого үүсгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,959,197.5 мянган төгрөг болж 152,109.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалжээ.

Хими, химийн технологийн хүрээлэнгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,667,056.5 мянган төгрөгөөр буюу 54 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Энэ нь 2019 онд биохимийн идэвхт лабораторийн барилга хүлээн авснаас болсон байна.

Нийт зардал өмнөх оноос 403,174.2 мянган төгрөгөөр буюу 14.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал түүнтэй холбоотой нийгмийн даатгалын шимтгэлийн зардлууд байна. Энэ нь нийт зардал өссөн шалтгаан болсон байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,745,333.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,745,333.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 68,062.2 мянган төгрөгөөр бууруулж 2,677,271.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Хими, химийн технологийн хүрээлэнг санхүүжүүлэхээр 2,677,271.5 мянган төгрөгийн төсөв баталсныг 100% улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,677,271.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,645,369.1 мянган төгрөгийг зарцуулж 31,902.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,645,369.1 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь Ковид-19 ээс шалтгаалж байр ашиглалт, хангамж бараа материалын зардал, цэвэрлэгээ

үйлчилгээг зарим саруудад аваагүйгээс болж 31,902.4 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс 380,229.5 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчаас 139,789.4 мянган төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 236,572.9 мянган төгрөг, түрээсийн орлого 6,048.0 мянган төгрөг, нэр данс зөрүү 1,010.0 мянган төгрөг, нийт 763,649.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа ажил үйлчилгээний зардалд 588,015.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 175,634.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 141 мэдээлэл, хугацаа хоцроосон 10 мэдээлэл байна.

2020 онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 34 гүйлгээ нийт 648,643.9 мянган төгрөгийн гүйлгээ байгаагаас шилэн дансны цахим хуудсанд shilendans.gov.mn/ 648,643.9 мянган төгрөгийн 34 гүйлгээг байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5 зөвлөмжийн 4 зөвлөмж нь биелсэн, 1 зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай байна. ТӨБЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 432 тоот Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай албан бичгээр БОАЖЯ-с шилжиж ирсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлж, ашиглалтын хугацааг шинээр тогтоогоогүй байна гэсэн зөвлөмж 50 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	5	3,962.0	4	3,962.0	1	-	50.0
Нийт дүн	5	3,962.0	4	3,962.0	1	-	50.0

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 75,222.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 75,222.8 мянган төгрөгийн зөрчилд алдаа гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга гараагүй болно.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар шилэн дансанд хугацаандаа оруулаагүй 10 мэдээлэлд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ. Үүнд:

1. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр заалт, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, ", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5 цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв, иж бүрэн, тасалбар болголт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газрын 2019 оны 432 тоот Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай албан бичгээр Байгаль Орчин Аялал Жуучлалын Яамнаас шилжиж ирсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлж, ашиглалтын хугацааг шинээр тогтоох талаарх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
Энэ нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 75,222.8 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 75,222.8 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн элэгдлийг дахин тооцоолж үзэхэд зарим үндсэн хөрөнгийн элэгдлийг 75,222.8 мянган төгрөгөөр дутуу байгуулсан байсан.

Энэ нь үнэн зөв байдал, хэмжилт, иж бүрэн байх, тасалбар болголт гэсэн батламж мэдэлдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 “Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.”Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

1.2. Эрсдэл:

Тайлант хугацааны зардал буруу илэрхийлэгдэх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн програмаар тооцоолж гаргасан элэгдлийг нягтлан бодогч хянаж байх, зарим үед давтан тооцоолж үздэг байх хэрэгтэй. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 “Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.”Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тухайн үндсэн хөрөнгийн элэгдэл нь 2019 болон 2020 оны элэгдэл юм. Программ ашиглалттай холбоотой зарим алдаа гардаг. Цаашид программын алдаа болон бусад алдааг давтан гаргахгүй ажиллана.УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”-ыг дагаж мөрдөнө.

2.Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Байгууллага дотоодын үйл ажиллагааны хүрээнд шинжлэх ухааны бүтээл гаргаж патент авдаг байна. Энэ патентыг цааш нь хөгжүүлж зах зээл дээр борлогдох бүтээгдэхүүн болгох, бүтээгдэхүүн үйлдвэрлэх борлуулж зах зээлд гаргахын тулд “Гарааны компани байгуулж туршилт маягаар ажиллуулдаг. Энэ компани бага хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулж зах зээлд нэвтрүүлдэг боловч гарааны компанийн өртөг зардал хүрээлэнгийн зардлаар бүртгэгдэж, орлого үр дүнгийн тайланд тусгагддаг.

Энэ нь толилуулга ба тодруулга, үнэлгээ, үнэн зөв байдал, хэмжилт, иж бүрэн байх, тасалбар болголт гэсэн батламж мэдэлдэлтэй нийцэхгүйгээс гадна Патентын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Хуулийн этгээд шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг ашигласнаас олсон ашиг, оюуны бүтээлийн өртгийг тооцсон үнэлгээг санхүүгийн тайлан тэнцэлд тусгаж, үйлдвэрлэлийн нууцыг нь хадгална”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2.2. Эрсдэл:

Биет бус хөрөнгө бүртгэгдэхгүй байх эрсдэлтэй

2.3. Өгсөн зөвлөмж:

Гарааны компанийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор гаргаж байгаа зардлыг биет бус хөрөнгөөр бүртгэх эсэх асуудлыг Боловсрол, шинжлэх ухааны яамны бүртгэлийн газартай хамтран шийдвэрлэх. Патентийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Хуулийн этгээд шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг ашигласнаас олсон ашиг, оюуны бүтээлийн өртгийг тооцсон үнэлгээг санхүүгийн тайлан тэнцэлд тусгаж, үйлдвэрлэлийн нууцыг нь хадгална”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

2012 оныг хүртэл Шинжлэх ухаан технологийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн оюуны өмчийн эзэмшигч нь захиалагч байгууллага буюу яам байдаг байсан. 2012 онд энэ зохицуулалт шинээр батлагдсан Инновацийн тухай хуулиар өөрчлөгдөж, судалгааны өмчлөгч нь судалгааны ажлыг гүйцэтгэсэн байгууллага байж болно гэсэн зохицуулалттай болсноор хүрээлэн эзэмших эрхтэй болсон ба зохицуулах журмыг Засгийн газар батлахаар заасан. "Төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, эзэмшүүлэх журам" Засгийн газар 2015 оны 267 дугаар тогтоолоор батлагдаж, эдгээр хууль, журмын дагуу 2012 оноос хойш батлагдсан патентуудын эзэмших эрхийг хүрээлэнгийн нэр рүү шилжүүлж эхлээд байна. 2020 онд батлагдсан Оюуны өмчийн тухай хуулиар тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд патентыг үнэлж, Оюуны өмчийн газар түүнийг нь баталгаажуулдаг зохицуулалттай болсон бөгөөд одоогоор оюуны өмчийг үнэлэх эрх бүхий зөвшөөрөл авсан хуулийн этгээд байхгүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Хими,химийн технологийн хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/83/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:	Хими,химийн технологийн хүрээлэн		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуул-лагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үндсэн хөрөнгийн элэгдэл дутуу тооцсон	75,222.8	Зөвлөмж өгөх	Ахлах Нягтлан бодогч Тооцооны Нягтлан бодогч	Ч.Гэрэлтуяа Ж.Магсаржав
2	Биет бус хөрөнгө буюу патенттай холбоотой	-	Зөвлөмж өгөх	Захирал	Л.Жаргалсайхан
3	Шилэн дансны мэдээлэл хугацаандаа оруулаагүй	-	Албан шаардлага өгөх	Ахлах Нягтлан бодогч Референт	Ч.Гэрэлтуяа Г.Уянга
4	Байгаль Орчин Аялал Жуучлалын Яамнаас шилжиж ирсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлж, ашиглалтын хугацааг шинээр тогтоох	-	Албан шаардлага өгөх	Ахлах Нягтлан бодогч	Ч.Гэрэлтуяа
ДҮН		75,222.8			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 027/АД160058

Улаанбаатар хот

САТ-0021/83/СТА-ТЧЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хими,химийн технологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 151 мэдээллээс хугацаа хоцроосон 10 мэдээлэл байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хими,химийн технологийн хүрээлэнгийн Захирал Л.Жаргалсайхан, Ахлах нягтлан бодогч Ч.Гэрэлтуяа, Референт Г.Уянга нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
КОНФИДЕНСЕ АУДИТ ХХК-ийн
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

П.АРИУНАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 226/А0160058

Улаанбаатар хот

СМ- 2021/33/СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хими,химийн технологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газрын 2019 оны 432 тоот Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай албан бичгээр Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яамнаас шилжиж ирсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлж, ашиглалтын хугацааг шинээр тогтоох талаарх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хими,химийн технологийн хүрээлэнгийн Захирал Л.Жаргалсайхан, Ахлах нягтлан бодогч Ч.Гэрэлтуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
КОНФИДЕНСЕ АУДИТ ХХК-ийн
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

П.АРИУНАА

